

СҮХБААТАР АЙМГИЙН **ХӨТӨЧ НОМ**



СҮХБААТАР

АЙМГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА МЭДЭЭЛЭЛ

Сүхбаатар аймгийн Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэр нь 1921 оноос өмнө Халхын Сэцэн хан аймгийн Чин ван хошуу, Далай ван хошуу, Ёст бэйс хошуу, Эрх гүн хошуу, Хурц засаг хошуу, Егүзэр хутагтын шавь хошуу гэсэн 6 хошууны нутаг, 1931 онд халхын 4 аймгийг 13 аймаг болгон өөрчлөхөд Хэнтий, Дорнод аймагт харъяалагдаж байлаа.

Аймгийн төв: Баруун-Урт хот

Хэдэн сумтай: 13

Нутаг дэвсгэрийн хэмжээ: 82,287.15 км²

Хүн ам: 61 323 хүн (2017 он)

Угсаатан: Халх, Дарьгангачууд

Малын тоо толгой: 498.0 мянган

Утасны код: +976 (0)151

Шуудангийн дугаар: 22000

ТХ-ийн улсын дугаар: СУ

Цахим хуудас: www.sukhbaatar.mn

Улсын бага хурлын 1943 оны 2 сарын 20-ны өдрийн тогтоолоор Жавхлант шарга аймгийг их жанжин Сүхбаатарын нэрэмжит болгож "Сүхбаатар аймаг" гэж нэрлэх болсон юм. Мөн ондоо аймгийн төвийг Баруун-Урт голын дэргэд шилжүүлэн суурьшуулж "Баруун-Урт" гэж нэрлэсэн байна.

Нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд 13 сум, 67 багтай. Монгол орны зүүн өмнөд хэсэгт 82.3 мянган хавтгай дөрвөлжин км нутагтай, тал хээрийн бүсэд багтдаг. Хамгийн өндөр цэг нь далайн түвшинээс дээш 1 778 м-т өргөгдсөн Шилийн Богд уул, хамгийн нам цэг нь далайн түвшнээс дээш 790 м-т өргөгдсөн Байшинт юм. Эдийн засгийн гол салбар нь мал аж ахуй, уул уурхайн салбар бөгөөд нутгийн шилмэл омгийн Баяндэлгэрийн улаан ямаа, Эрдэнэцагааны үзэмчин хонь, Түмэнцогтын махны хэвшлийн үхэр, хурдан удмын адуун сүрэг, уул уурхайн хувьд цайр, зэс молибден, хүрэн нүүрс, хайлуур жонш, гянтболд зэрэг орд газруудтай.

говьд аргаль, янгир, цагаан зээр, хар сүүлт, хойлог зэрэг ан амьтан элбэгтэй бөгөөд дэлхийн улаан номонд бичигдсэн дархан цаазат хулан, ирвэс ч байдаг.



БАРУУН-УРТ

ХОТЫН ТУХАЙ



1943 онд аймгийн төв Баруун-Урт хэмээх бяцхан голын хөвөөнд шилжин суурьшсанаас эхлэн тэр голын нэрээр нэрлэгдэх болжээ. АИХ-ын тэргүүлэгчдийн 1957 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн 115 дугаар зарлигаар аймгийн төвд 4 хоринтой хороо захиргааны нэгжийг байгуулж бие даасан үйл ажиллагааны эхлэлийг тавьсан бөгөөд улмаар 1965 онд Баруун-Урт хот гэж нэрлэн хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаа болгон эрх үүргийг нь өргөтгөсөн байна.

Өрхийн тоо: 7114

Хүн амын тоо: 20,4 мянга

Улаанбаатар хотоос алслагдсан зай: 560 км

СҮХБААТАР АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МАРШРУТУУД

Маршрут-1

/Бичигт боомт – Дарьганга сум –
Эрдэнэцагаан сум – Бичигт боомт
/558 км/

Чиглэл нь: Нэг дэх өдөр 205км
Бичигт боомт –15- Лхачинвандад уул
-30- Wood house жуулчны бааз–30 -
Эрдэнэцагаан сум –70- Зотол хан
уул–60- Талын агуй /хоноглох/
Хоёр дах өдөр 80 км
Талын агуй-30-Бичигтийн шахаа -2-
Хөргийн хөндий -3- Шилийн богд
жуулчны бааз -45- Нью Дарьганга
амралтын газар /хоноглох /
Гурав дах өдөр 228км
Дарьганга сум -20- Ганга нуур -8-
Торой бандийн хөшөө -50- Шилийн
богд уул -120- Эрдэнэцагаан сум -30-
Wood house жуулчны бааз
/Хоноглох/
Дөрөв дэх өдөр 45км
Wood house жуулчны бааз -45-
Бичигт боомт

Маршрут-2

/Бичигт боомт – Дарьганга сум –
Халзан сум – Баруун-Урт – Асгат
сум – Эрдэнэцагаан сум – Бичигт
боомт /884 км/

Чиглэл нь: Нэг дэх өдөр 205 км
Бичигт боомт –15- Лхачинвандад
уул –30- Wood house жуулчны бааз
–30- Эрдэнэцагаан сум –70- Зотол
хан уул –60- Талын агуй /хоноглох/
Хоёр дах өдөр 138 км
Талын агуй –15- Шилийн богд уул
-45- Бичигтийн шахаа -2- Хөргийн
хөндий -3- Шилийн богд жуулчны
бааз -45- Торой бандийн хөшөө -8-
Ганга нуур /оргихын булаг/ -20- Нью
Дарьганга амралтын газар
/хоноглох/
Гурав дах өдөр 80 км
Дарьганга сум -80- Хүрээ бүрд
жуулчны бааз /Хоноглох/
Дөрөв дэх өдөр 123 км
Хүрээ бүрд жуулчны бааз -60-
Халзан сум -63- Баруун-Урт

Маршрут-3

/Баруун-Урт – Халзан сум –
Дарьганга сум – Эрдэнэцагаан сум –
Бичигт боомт – Сүхбаатар сум –
Баруун-Урт /1182 км/

Чиглэл нь: Нэг дэх өдөр 135
Баруун-Урт- 63- Хатавчийн хавцал-
32- Замын нуур- 40- Хүрээ бүрд
жуулчны бааз
Хоёр дах өдөр 285
Хүрээ бүрд жуулчны бааз- 25- Цагаан
худаг хүн чулуу-15- Онгон сум -60-
Таван толгойн хүн чулуу-40- Будрын
чулуу -35- Хулгайчийн шанд- 30-
Шивээтийн хүн чулуу -80-Сөдөтийн
цагаан чулуу
Гурав дах өдөр 88
Сөдөтийн цагаан чулуу- 28- Наран
сум -30- Хүнт ухаа хүн чулуу -30-
Дарьганга сум
Дөрөв дэх өдөр 119
Дарьганга сум -20- Ганга нуур -8-
Гангын цагаан овоо -45- Хөргийн
хөндийн хүн чулуу-2 Бичигтийн
шахаа-30- Талын агуй-14- Шилийн
богд уул

Маршрут-4

/Баруун-Урт - Шилийн богд -
Дарьганга сум - Баруун-Урт
489км/

Чиглэл нь:
Баруун-Урт –45км- Асгат сум –10
км- Сүхбаатар аймгийн төв цэг
–120км- Бичигтийн шахаа –2км-
Хөргийн хөндий –5км- Шилийн
богд жуулчны бааз –25км- Талын
агуй –14км- Шилийн богд –50км-
Торой бандийн хөшөө –8км- Ганга
нуур –20км- Дарьганга сум –70-
Хүрээ бүрд жуулчны бааз -120км-
Баруун-Урт.хийд

ҮЗМЭРҮҮД

СҮХБААТАР АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

АЛТАН ОВОО

Монголын эрсийн цог хийморийг бэлгэдэл болсон Алтан-Овоо буюу Дарь овоо нь Сүхбаатар аймгийн нутагт Молцог элсний хойд захад Дарьганга сумын төвийн дэргэд оршдог. Далайн түвшинээс дээш 1354 метрийн өндөрт өргөгдсөн энэхүү уул нь унтарсан галт уул аймгийн төвөөс 180 км зайтай. Галт уулын шовгор хэлбэр нь эвдрээгүй үлдсэн, галт уулын хүрмэн чулуу их, амсар нь баруун хойшоо сэтэрч урссан. Дарьгангын байгалийн цогцолборт газарт багтана.

Дарь Овоог эрт үеэс нутгийн ард олон төдийгүй ихэс дээдэс тахиж шүтэж ирсэн гэдэг. Чухам хэдий үеэс тахиж шүтэж ирсэн нь тодорхойгүй боловч XIII зууны үед тахиж байсан гэж үзэх үндэс бий. Дарь Овоог урьд "Захын хар өндөр" хэмээн нэрлэдэг байсан хэмээн нуггийн хөгшид өгүүлсэн нь тун сонин юм. Дарьгангад Манжийн эзэн хааны сүрэг байгуулагдсаны дараа тус нутгийн тахилгат овоог бий болгох асуудлаар нутгийнхны дунд маргаан үүсэж, зарга тэмцэл болсны эцэст Манжийн хааны зарлигаар Дарь Овоог жил бүрийн хаврын эхэн сар ба зун хоёр удаа тахихаар болсон. Ийнхүү Дарь Овоог тахихдаа оройд нь гэр хэлбэртэй "Батцагаан" хэмээх дугуй цагаан суварга барьж дээр нь олон давхар зузаалан алтадсан зэс ганжир шүншиглэн босгож тэр нь хаа холоос шижиртэн туяарч харагддаг болсноос "Алтан Дарь-Овоо" гэх болжээ.



Photo by: B. Shineb

ҮЗМЭРҮҮД

СҮХБААТАР АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

ШИЛИЙН БОГД

Сүхбаатар аймгийн Дарьганга суманд зүүн урагш 60 км-т далайн түвшнээс дээш 1778 метрт оршдог. Дарьгангын энэ өндөрлөг тэгш газарт 200 орчим унтарсан галт уул байдгийн хамгийн өндөр нь Шилийн богд уул юм. Мөн энэ нутагт 60 орчим хүн чулуу бий. Шилийн Богд уулан дээрээс Зотол хан, Дөш зэрэг 200 орчим эртний сөнөсөн галт уулыг харж болох бөгөөд уулсын оройг зориуд засаж янзлан зүсэж авсан мэт үнэхээрийн үзэсгэлэнтэй харагдана. Энэ хавийн уулс нь Авдар, Дөш, Сэнжит, Ацаа гэхчилэн галт уулын шовгор дүрс хэлбэрээрээ нэрлэгдсэн байдаг. Их талын хамгийн өндөр уул учраас тал дээр хааш хаашаа 60-аад км алсаас майхан барьчихсан юм шиг шовгор харагддаг. Шилийн богдын зүүн дор Агтны хүрээ гэж дугуй тогоотой талын намхан галт уул бий. Шилийн богд дээрээс тод харагдана. Уулсын хоорондын хөндий талаар хүрмэн чулуун лав тогтсон тул тэдгээрийн гадарга нилээд чулуурхаг юм.

Хар хүрэн, хүрэн бараан хөрс зонхилдог. 108 зүйлийн ургамал ургадаг бөгөөд ойт хээр, хээр, говийн бүсийг төлөөлж чадах нэн ховор ургамал 30 гаруй зүйл бий.

Амьтны аймгийн хувьд туурайтан мэрэгчид голлох бөгөөд цагаан зээр, тарвага, чоно үнэг элбэг үзэгдэнэ.

2004 онд Шилийн богд уулыг ойролцоо орших Хөрөгийн хөндийн хамтаар байгалийн нөөц газарт тооцож улсын тусгай хамгаалалтад авсан.



ҮЗМЭРҮҮД

СҮХБААТАР АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

МОНГОЛЫН ХҮН ЧУЛУУД

Хүн чулуу нь эртний хүмүүсийн шүтлэг бишрэл, нийгмийн харилцаа, соёл урлагийн төвшин, угсаатны онцлог, зан заншил зэрэг олон асуудлыг тодруулж сэргээн судлах шинжлэх ухааны нэн үнэтэй сурвалж болдог ажээ.

Түрэгийн үеийн хүн чулуу нь гол мөрний сав хөндий, тэдгээрийн ойр орчим тэгш сайхан тал зэрэг олны хараанд өртөхүйц байгалийн үзэмжит газар нутагт цогцлон байгуулсан тахил шүтээний байгууламжийн бүрэлдэхүүнд орж байрласан байдаг ажээ. Их монгол улсын үед хамаарах хүн чулуудын ерөнхий төрх нь баруун гартаа хундага сав барьж түшлэгтэй сандалд суусан эр хүний дүрс зонхилдог, түрэгийн хүн чулуунд байдаг шиг зэл чулуу байдаггүй. Их монголын үед холбогдох эдгээр хүн чулуунуудыг хамгийн ихээр агуулдаг газар бол Сүхбаатар аймгийн нутаг бөгөөд “Дарьгангын хүн чулуу” хэмээн алдаршчээ.

Хөргийн хөндий. Дарьганга сумаас зүүн тийш 45 км-т хойноосоо урагш чиглэлтэй нарийхан хөндий бий. Энэ хөндий дунд хөрөг зураг гэлтэй 7 хүн чулуун хөшөө байдаг. Эдгээр хүн чулуунууд XIII-XIV зууны түүхэнд хамаарах бөгөөд ихэнх нь малгай гуталтай хирнээ биедээ ямар ч хувцасгүй дүрслэгдсэн онцлогтой. Түүнчлэн бүгд наран ургах зүгт хандсан байрлалтай.



ҮЗМЭРҮҮД

СҮХБААТАР АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

ТАВАН ТОЛГОЙН АРХЕОЛОГИЙН ЦОГЦОЛБОР

Онгон таван толгойд археологич Д.Наваан гуай МУИС-ийн археологи, антропологийн ангийн оюутануудтай XIII- XIV зууны булшийг малтаж, шинжлэх ухааны онцгой ач холбогдолтой олон гайхамшигт дурсгалуудыг олсон юм. Түүний дотор Боржигон овгийн алтан ургийн цагаан шонхор шувууны дүрс нууцалж сийлсэн шигтгээтэй алтан бөгжийг Д.Наваан гуай “Дарьгангын алтан шонхор” хэмээх нэрээр шинжлэх ухааны эргэлтэд оруулсан байна. Мөн археологич, доктор Ц.Төрбат Онгон таван толгойд малтлага хийж мөн маш ховор чухаг олдвор олж нээсэн бөгөөд ясан тамга, исэр сандал зэрэг нь шинжлэх ухааны онцгой олдвор хэрэглэгдэхүүн ажээ.

Богтаг малгайн алтан цог чимэглэл. Галын дөл мэт угалзарсан хэлбэртэй, нарийн алтан утсаар цэцэг ургамлын дүрс гаргаж зай завсаргүй сүлжин чимэглэсэн, үнэт чулуун шигтгээтэй. Уг чимэглэл 5 см өндөр, 5.6 см өргөн, 0.5 см зузаан, 22.7 гр жинтэй.

Цагаан чулуун жинстэй соновторж. Гуулин ялтсаар хөөмөлдө алтаар шарж хийсэн дөрвөн дэлбээтэй суурин дээр жижгэвтэр зургаан дэлбээт бадам цэцгийг дүрсэлж тана мэт чулуун жинс суулгасан.



ҮЗМЭРҮҮД


СҮХБААТАР АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

ГАНГА НУУР

Сүхбаатар аймгийн Дарьганга сумын төвөөс 12 километр орших салхины нүүдлээс үүссэн хурмал элсэнд хаагдаж тогтсон нэгэн нуур байх бөгөөд түүнийг Ганга нуур гэдэг. Ганга нуур нь 4 ам километр талбайтай нуур бөгөөд Ганга гэдэг нь үүрд ширгэшгүй ундрэн оргилдог мөнх гэсэн утгатай үг ажээ. Ганга нууранд Монголын улаан номд ордог гангар хун, цэн тогоруу гэх мэт нэн ховор шувууд ирж зусдаг.

Жил бүрийн намар хун шувууд олон зуугаараа нисэн ирж ганганан чуулдаг учраас Ганга нуурын 1000 хунгийн чуулган гэж алдаршсан юм. Ганга нуурыг усыг 21 булаг тэтгэн тэжээдэг бөгөөд тэдний гол амин судас нь Дагшин оргихын булаг билээ. Нуурын зүүн хойно 50 метр зайд газрын гүнээс тунгалаг устай хүйтэн булаг оргилон гардгийг Оргихын булаг гэж нэрлэдэг. Нарийн ширхэгтэй элсний доороос даргилан буцалж байгаа юм шиг оргилон гарах бөгөөд чангаар дуугарах тусам улам ихээр элс бужигнан оргилдог онцлогтой билээ.

Ганга нуурын ойролцоо төрийн тахилгат Алтан-Овоо, Молцог элс зэрэг байгалийн аялал жуулчлал хөгжүүлэх боломжтой газруудыг хамгаалах зорилгоор 2004 онд УИХ-ын 22 дугаар тогтоолоор улсын тусгай хамгаалалтанд авсан. Ганга нуур нь талбай бага хэдий ч цэнгэг устайн дээр өвөрмөц бичил уур амьсгалыг бүрдүүлдэг.



ҮЗМЭРҮҮД

СҮХБААТАР АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

ХУНГИЙН ЧУУЛГАН

Жил бүрийн намар Сүхбаатар аймагт орших Ганга нуурын хөвөөнөө буцах хунгийн сүрэг чуулдаг.

Аймгийн иргэдийн ярж байгаагаар усны гэгдэх шувууд бөмбөрцгийн хойд талаас эхлэн сэрүүсэхээр хүйтэнд шахагдан хоол тэжээл, дулаан нутаг бараадан намрын турш аажмаар урагшилдаг гэж байна. Энэ урагшлалт нь Өмнөговь, Дорноговь, Баянхонгор чиглэлээр нисэх боломж бараг байдаггүй гэнэ. Яагаад гэвэл тэнд цөл, говийн бүс үлэмж урт үргэлжилж нуур цөөрөм байхгүйтэй холбоотой хэмээн ярилаа.

Монголын нутаг дэвсгэр дээгүүр шувууны гурван их зам гардаг юм байна. Үүний нэг нь Сүхбаатар аймгийн өмнүүр байдаг олон нуур цөөрмүүд юм. Түүний нэг нь Ганга нуур гэнэ. Жил бүрийн 10 дугаар сард тус аймгийг зорих дотоод жуулчдын тоо эрс нэмэгддэг байна. Тэд бүгд л “Хунгийн чуулган” үзэж нүдээ баясгаж, сэтгэлээ амраахыг зорьдог байх нь.

Жил бүрийн 10 сард буюу 7-9 ны өдрүүдэд “Хунгийн чуулган” болдог байна.



ҮЗМЭРҮҮД

СҮХБААТАР АЙМГИЙН 7 ГАЙХАМШИГ

ЕГҮЗЭРИЙН ХИЙД

Егүзэрийн хийд нь 1780 онд Сэцэн хан аймгийн тайж Ренчиндоржийн хошуунд Манжийн хааны зарлигаар анх байгуулагджээ. Одоогийн Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт Чоно голын хойд дэнж дээр байгуулагдсан бөгөөд Цагаан-Овоо, Хуран, Алтан-Овоо, Чандмань зэрэг 4 тахилгат уулын дунд байрлажээ.

Оточ нарын мамба, философийн чойр, харь зүгийн жүдэв, лүүжин тавигчдын хажид, цагийн хүрдний онол зурхайн дүйнхор гэсэн дацангуудаас гадна цогчин дуган, сэрүүн лаврин, баруун зүүн сэрдэн, суварга, зуугийн сүм зэргийг байгуулжээ. Анхны Егүзэр лам нь Лувсанбалдан хэмээх хүн байжээ.

Егүзэрийн хийд нь Оросын II Екатерина хааны тосгоны бүтэц бүхийгээр баригджээ. Орд маягийн 20 гаруй байшинтай, хятад, япон, түвд, Монгол загварын барилгуудтай байжээ. Өдөр бүр байнга хурал ном хурж, бүрээ бишгүүр, хэнгэрэг цангийн дуу нижигнэсэн, маш хөл хөдөлгөөнтэй хийд байжээ. Их бага жастай байсан бөгөөд жасын хашаанд 6 ханатай том гэрт 8 тотго бүхий тулга тулж, түүн дээр 4 бариультай том тогоо тавиаастай байв. Энэхүү тулга тогоо нь жил бүр Егүзэрийн хийдийн тахилга үйлддэг гал голомт байжээ. Цогчин дуганы үүдэнд өөд өөдөөсөө харсан 2 сүм байсан бөгөөд зүүн сүмийн урд "жинлүү" хэмээх хонх, баруун сүмийн өмнө "гүнлүү" хэмээх том хэнгэрэг байрлуулсан байжээ.



БУСАД ҮЗМЭРҮҮД



ЭХИЙН АГУЙ

Эрдэнэцагаан сумаас баруун тийш 50 гаруй км-т орших Зотолхаан уулын ар дор байх “Эхийн агуй” нь хоёр салаа амтай, хонгил нь 6-7 хүн багтах уужим зайтай. Орсон хүн хонгилоос зүүн тийш чиглэсэн 4м урт нарийн ганц хүн багтах сувгаар мөлхөн гадагш гардаг. Үүгээр гарсан хүн дахин төрж ариуслыг оллоо гэж үздэг. Үүнийг “Эхийн агуй” гэх ба энэ нь газрын хөрсөн дээр тогтсон хүрмэн чулуун тогтоц юм.

БИЧИГТИЙН ШАХАА

Энэ газар нь одоогийн Дарьганга сумын төвөөс зүүн хойш 40-өөд км-т байдаг. Зүүн талаасаа огт мэдэгдэхгүй цэлийсэн тал үргэлжилж байгаад гэнэт доош цөмрөх мэт эгц буусан 40-өөд м-ийн өндөртэй, 90 градусын эгц, 1 км хэртэй урт хадан хясаа юм. Буу зэвсэг ховор байсан үед хүмүүс энэ гайхамшигт хясааг ан гөрөөний ажилд ашиглан зээр гөрөөсийг үй олноор нь сууриар нь шахаж оруулан агнадаг байжээ. Ийм учраас “Шахаа” нэрийг олсон байна гэсэн домогтой. Энэ “шахаа”-г “Бичигтийн” гэж нэрлэсэн тухайд: уул хадан хясааны эгц энгэрүүдээр их хэмжээний бичгүүд байснаас болсон гэх бөгөөд тэр бичгүүдийг “Амьтныг ингэж үүрээр нь сүйтгэж болохгүй” гэсэн харуулсын бичээс байсан гэсэн домог үлджээ.

АВДАРЫН ХИЙД

Авдарын хийд нь Ёст бээсийн хушууны төвөөс баруун урагш 50-иад км-т Дэлгэр овооны энгэр Авдар хад, Авдарын голын дэргэд байгуулагдсан. 1930-аад оны байдлаар 100 орчим ламтай дөрвөн дацантай, арваад сүм дугантай, хурлын газартай байсан. Хийд байнгын хуралтай байсан бөгөөд “Дэлгэр овоо”, ялангуяа Авдар хадаа их шүтдэг, хад нь яг л авдар шиг бөгөөд түүн дээрээ Намсрай бурханы хөрөг байрлуулж, өглөө болгон манз, идээний дээжээ өргөн сан, уншлага үйлддэг байсан. Үүнийгээ эрдэнийн сан хадгалагдсан гэдэг байлаа. Уг хийдэд Жүд-Агийн, Мамба-эмчийн дацан, цогчинд, Бурхан багшийн дүйцэн өдрүүдэд хурал ном үргэлжлэн, сүжигтэн олон тасардаггүй байлаа. Хийдийн нэр Адвар хадаараа нэрлэгдсэн билээ.

БУСАД ҮЗМЭРҮҮД

МОРИН ХУУРЫН ЦОГЦОЛБОР

Энэ цогцолбор нь Дарьганга, Онгон, Наран сумдын нутгаар дайран өнгөрөх төв замд ойр, цогцолбор дээрээс Дарьгангын үзэсгэлэн төгс байгаль, уул ус эргэн тойрон нь харагддаг өндөрлөг газар болно.

Энэхүү цогцолбор нь 7.2 метр өндөр, 4.8 метр өргөн чандмалсан гурвалжин хэлбэрийн Морин хуурын цогцолбор юм.



ТАВАН ТОЛГОЙН ХҮН ЧУЛУУ

Онгон сумын төвөөс баруун урагш 30 гаруй км зайтай Таван толгойн хэмээх намхавтар ухаа толгодын дунд 2 хүн чулуун хөрөг бий. Уг хөрөг нь хийц, дүрслэл, бүтээсэн ур чадварын хувьд нийт монгол нутагт байгаа хүн чулуудын дотор нэн онцгой бөгөөд ерөөсөө Төв азийн хүн чулуу бүтээх урлагийн оргил нь гэж үзэж болно. Эдгээр хөргүүдийг цагаан болон хөх өнгийн гантиг чулуугаар түшлэгтэй, зөрүүлсэн хөлтэй исэр сандалд залран сууж буй байдлаар урлан хийж уртавтар гонзгой дүгрэг хэлбэртэй чулуун байгууламжийн зүүн өмнө хэсэгт тавьсан байна. Эдгээр хөргүүдийн төрх намба, хувцас өмсгөл, гэзэг үсээ засаж янзалсан байдал тэргүүнтэн нь XIII-XIV зууны монгол хаад язгууртны дүр төрхийг илтгэх бөгөөд дурьдсан цаг үе холбогдох уран зургийн дурсгал, эртний судлалын малтлагаар илрэн олдсон эд өлгийн зүйлстэй бүрэн дүйцэж байна.



БУДРЫН ЧУЛУУНЫ ЗУРАГ

Онгон сумын төвөөс баруун урагш 70 км-т Бударын чулуу хэмээх газар энэхүү эртний дурсгал орших ба нутгийнхан "Догшин Бударын чулуу" хэмээн нэрлэдэг хад цохиот сонин тогтоц бүхий газар юм. Бударын чулууны дунд хавьцаах ханан хаднаа хоёр хэсэг газар хүн, адуу мал, ан амьтдын дүрсийг бүх талбайгаар нь хонхойлгон сийлсэн байна. Энэ дурсгалыг 1996 онд Монгол, Солонгосын хамтарсан "Дорнод монгол" төслийн хээрийн шинжилгээний экспедиц илрүүлэн судалсан байна. Бударын чулууны зурагт зээр, чоно зэргийг ихэд цэвэрхэн, тод томруун дүрсэлсэн байх бөгөөд адуу мал, хүн рүү хандан зог тусан зогсож, үргэн зайлж байгаагаар харуулжээ. Нэг сонирхолтой нь могойн зураг юм. Могойг хадны зурагт дүрсэлсэн нь элбэг байдаг бөгөөд эртний хүмүүс могойг сайн, муу үйлийн аль алинд нь билэгшээж байсан гэж үздэг.



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГУУД



АЛТАН ОВОО ОРЧМЫН БААЗУУД



ТАЛЫН АГУЙ

📍 Сүхбаатар аймгийн
Дарьганга сум

☎ 99261659
96061659

🌐 [facebook.com/талын агуй жуулчны бааз](https://www.facebook.com/талын-агуй-жуулчны-бааз)

📍 lounge.resistors.showroom
46.2729° N, 102.7790° E



ГАНГАР ХУН

📍 Сүхбаатар аймгийн
Дарьганга сум

☎ 99170299
96040696

🌐 [facebook.com/gangankhuncamp/](https://www.facebook.com/gangankhuncamp/)

📍 lounge.resistors.showroom
46.2729° N, 102.7790° E



ДАГШИН БУЛАГ

📍 Сүхбаатар аймгийн
Дарьганга сум

☎ 96260066
95043299

🌐 [facebook.com/dagshinbulagcamp/](https://www.facebook.com/dagshinbulagcamp/)

📍 lounge.resistors.showroom
46.2729° N, 102.7790° E



ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУД

КИЛ

БАРУУН-УРТ ХОТЫН ЗОЧИД БУУДЛУУД



ДАРЪГАНГА

📍 Сүхбаатар аймгийн
Баруун-Урт хот

☎ 77433333

📘 www.facebook.com/darigangahotel

📍 lounge.resistors.showroom
46.2729° N, 102.7790° E



ТАНСАГ

📍 Сүхбаатар аймгийн
Баруун-Урт хот

☎ 222444, 99112001

📘 www.facebook.com/tansaghotel

📍 lounge.resistors.showroom
46.2729° N, 102.7790° E



УРГАХ НАРАН

📍 Сүхбаатар аймгийн
Баруун-Урт хот

☎ 70518285 94788800

📘 www.facebook.com/urgakhnaranhotel

📍 lounge.resistors.showroom
46.2729° N, 102.7790° E

ЭВЭНТ БАЯР НААДМУУД

АГТАНА ХҮРЭЭТ- ХҮЛЭГТ ЭРСИЙН НААДАМ

Монгол адуу, түүнийг дагасан соёл уламжлалаа өвлүүлэн үлдээх, түгээн дэлгэрүүлэх, гэрэл зургаар баримтжуулах, хамгаалах, дэлхий нийтэд сурталчлах, улмаар хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилготой.

ХУГАЦАА:
11 сарын 7

**ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ
ГАЗАР:**
Шилийн богдын ар бэлд

ХӨТӨЛБӨР:

- Шилийн богдын оройгоос ургах улаан нарыг харах
- адуучдын авхаалж сорьсон уурга шүүрэх, ташуур шүүрэх, морьтой шургуу, эмнэг булгиулах, ур чадварын чөлөөт үзүүлбэрүүд
- "Хос морьтон" шалгаруулах тэмцээн
- Адуучин тэмцээн
- гүүний дуудлага худалдаа



ТАЛЫН ӨГЛӨӨ" ШИНЭ ОНЫ АНХНЫ НАР ХАРАХ АЯЛАЛ

Сүхбаатар аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Биеийн тамир спортын газар, Боловсрол соёл, урлагийн газар хамтран "Уул ус, байгаль дэлхийдээ хүндэтгэл үзүүлэх болон шинэ оны анхны нарнаас энерги авах, дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх, дээлтэй монгол арга хэмжээг сурталчлах, нийтийн биеийн тамирын арга хэмжээг түгээн дэлгэрүүлэх зорилготой.

ХУГАЦАА:
1 сарын 1

**ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ
ГАЗАР:**

Баруун-Урт хотоос урагш 30 гаруй километр байх Баяншарга ууланд


ХӨТӨЛБӨР:

- Мөнгөн өвөл" монгол үндэстний өвлийн хувцасны үзүүлбэр
- сумо бөхийн барилдаан
- "хөгжөөнт буухиа
- морьтон залуучуудын дунд ташуур шүүрэх тэмцээн
- Сайхан дээлтэй хос



7. Агуй сонирхох аялал

	Аялах зам	Үзэх зүйл	Тайлбар
1 дэх өдөр 120 км	Баруун-Урт -45км- Асгат сум -75км- Авдарын цагаан толгой -35км- Зотол хаан уул	Хялганат тал хээр, эхий агуй, сөнөсөн галт уул,	Хээр хоноглоно.
2 дах өдөр 58 км	Зотол хаан уул -35км- Талын агуй -14км- Шилийн богд уул -9км- Шилийн богд жуулчны бааз	Монгол оронд мэдэгдээд байгаа галт уулын гаралтай хамгийн том агуй үзэж, шилийн сайн эрсийн уулан дээр гарч хийморно сэргээн.	Шилийн богд жуулчны баазад хоноглох.
3 дах өдөр 94 км	Шилийн богд жуулчны бааз -42км- Торой бандийн хөшөө -35км- Баяндулаан уул -17км- Мандалын хүн чулуу	Шилийн сайн эр Торой бандийн хөшөө, Баяндулаан уулын агуй, 13-14 зууны үеийн хүн чулуу	Хээр хононо.
4 дэх өдөр 73 км	Мандалын хүн чулуу -9км- Сөдөтийн цагаан чулууны бичээс -14км- Наран сум -50км- Дарьганга сум	Мин улсын хааны бичиж үлдээсэн бичээс, яруу найрагч О.Дашбалбарын төрсөн сумтай танилцах	Аян замын алжаалаа тайлж Зэгст нууранд усанд орж халуун элсэнд биеэ шаран Нью дарьганга амралтын газар хонох.
5 дах өдөр 170 км	Дарьганга сум -25км- Баруун нар -145км- Баруун-Урт сум	Дээхэн үед лам нарын ном судар, бурхан тахилаа хадгалж байсан агуйг үзэх	Агуй сонирхох аялалаа өндөрлөж Баруун-Урт суманд ирж хононо.



ТУСГАЙ СОНИРХОЛЫН АЯЛЛЫН МАРШРУТ